



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2024 оны 08 сарын 20 өдөр

Дугаар 06

Номгон

Г Төв суурин газрын 2024-2025 оны Г
өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах тухай

Байгалийн болзошгүй гамшиг, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, Төв суурин газрын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлыг шуурхай зохион байгуулах, түүнд тавих хяналтыг сайжруулах зорилгоор Баянхонгор аймгийн Засаг даргаас **ДААЛГАХ НЬ:**

Нэг. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт даалгах нь:

1.1. Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилга, байгууламж, зам гүүрийг шинээр барих болон арчлалт, засварын ажлуудыг хугацаанд нь чанартай гүйцэтгүүлж, ашиглалтад оруулах, он дамжих барилгуудыг хамгаалалтын горимд шилжүүлэх;

Хоёр. Чандмань-Баянхонгор ХК-д даалгах нь:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажилд хяналт тавьж, хамтран ажиллах;

2.2. Баянхонгор сумыг цэвэрлэх байгууламжийн лагийг зайлуулах;

2.3. Ус хангамжийн эх үүсвэрт нөөцийн дизель суурилуулах;

2.4. Бохир усны төв болон салбар шугам сүлжээнд цэвэрлэгээ үйлчилгээ тогтмол хийх;

2.5. Дулаан, цэвэр усны төв болон салбар шугам сүлжээнд засвар үйлчилгээ хийх;

2.6. Төрийн болон төсөвт байгууллага, аж ахуйн нэгжийн засварын ажлыг бүрэн дуусган, үйл ажиллагааг жигдрүүлэх, хяналт тавих, арга зүйн зөвлөмжөөр хангах;

Гурав. Баянхонгор-Эрчим хүч ЦТ ХХК, Эрчим хүчний зохицуулах зөвлөлд:

3.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэн нөхцөлд халаалтын зуух болон нэгдүгээр зэрэглэлийн хэрэглэгчдийн

642402009

цахилгаан хангамжийн схемийг шинэчлэн, аваарын нөөц эх үүсвэр /дизель станц/-тай болох, шаардлагатай дизель түлшний нөөцийг бэлэн байлгах;

3.2. 110/35/10 кВ-ын "Баянхонгор" дэд станц"-ын өргөтгөл, шинэчлэлийн ажилд хяналт тавьж гэрээний хугацаанд нь ашиглалтад оруулах;

3.3. Дулаан үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн дулаан, цэвэр усны шугам сүлжээнд засвар үйлчилгээ тогтмол хийлгэх;

3.4. Дулаан үйлдвэрлэгч тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд нэг сараас дээш нүүрсний нөөц бүрдүүлэлт хийх;

3.5. Халаалтын улиралд гэнэтийн аваар саатал гарсан үед гэмтэл устгах болон сэргээн засварлахад анхаарч ажиллах, аваарын нөөц сэлбэг материал бүрдүүлэлтэд хяналт тавих;

3.6. Аймгийн төв баригдаж байгаа дулаан станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтцийн ажилд хяналт тавих;

3.7. Орон нутгийн цахилгаан хангамжийн өргөтгөл, шинэчлэлтийн ажилд хяналт тавих;

3.8. Дулаан үйлдвэрлэгч тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд агаарын бохирдлыг бууруулахад анхаарах, үнс хог хаягдлыг хадгалах савыг бэлтгэх, сайжруулах;

3.9. 2.6.Төрийн болон төсөвт байгууллага, аж ахуйн нэгжийн засварын ажлыг бүрэн дуусган, үйл ажиллагааг жигдрүүлэх, хяналт тавих, арга зүйн зөвлөмжөөр хангах;

Дөрөв. Дулаан үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн удирдлагад даалгах нь:

4.1. Дулааны зуухны тоноглол, насос станц, төв магистраль шугам сүлжээнд үзлэг шалгалт хийж, засвар үйлчилгээг 2024 оны 9-р сарын 20-ны дотор хийж дуусгах;

4.2. Жилийн хэрэгцээт нүүрсний 40 хувийг нөөцлөн бэлтгэх;

4.3. Хэрэглэгч аж ахуйн нэгжүүдийн засвар, үйлчилгээг шаардаж хийлгүүлэх;

4.4. 2.6.Төрийн болон төсөвт байгууллага, аж ахуйн нэгжийн засварын ажлыг бүрэн дуусган, үйл ажиллагааг жигдрүүлэх, хяналт тавих, арга зүйн зөвлөмжөөр хангах;

Тав.Сумдын Засаг дарга нарт даалгах нь:

5.1.Сумын төсөвт болон аж ахуйн нэгж байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг батлан хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллах;

5.2. Төсөвт байгууллагуудын дулаан алдагдлын байдалд шалгалт хийц, цонх, хаалга, дулааны шугам сүлжээний дулааны алдагдлыг засах ажлын хэрэгжилтийг хангуулах;

5.3. Уурын зуухны шугам сүлжээнд үзлэг шалгалтыг хийлгэх, зайлшгүй шаардлагатай засвар үйлчилгээг хийлгэх;

5.4. Жилийн хэрэгцээт нүүрсний 40 хувийг нөөцлөн бэлтгэхэд хяналт тавьж ажиллах;

5.5. Сургууль, цэцэрлэгийн барилгын засварын ажлыг хичээл эхлэхээс өтнө дуусгах, гүйцэтгэлд хяналт тавих;


5.6. Төсөвт болон аж ахуйн нэгж байгууллагуудын инженерийн шугам сүлжээ, тоноглолд (халаалт, цэвэр, ариутгах татуургын шугам сүлжээ, худаг) засвар үйлчилгээ хийлгэх ажилд хяналт тавьж ажиллах;

5.7. Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг 14 хоног тутам Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст мэдээлж байх;

Зургаа. Тайлагналт:

6.1. Албан даалгаврын хэрэгжилт, төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлын тайланг 2024 оны 9 дугаар сарын 25-ны дотор нэгтгэн, шаардлагатай бол газар дээр нь биечлэн танилцаж Онцгой комиссын хуралд танилцуулахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН